

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2025 оны 09 дугээр сарын . 09 -ны өдрийн 14:10 . дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

1701282 СБА-4-2740 1119283239

Сэдэв: “Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил: Онол, чиг хандлага”

Зорилго: Кибер гэмт хэргийн олон улсын болон дотоодын нөхцөл байдал, чиг хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмж боловсруулахад оршино.

Зохион байгуулагч:

- Дотоод хэргийн их сургууль
- Монголын Улаан Загалмай нийгэмлэг

Оролцогч байгууллага:

- Улсын Дээд шүүх
- Улсын Ерөнхий Прокурорын газар
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Хүний эрхийн Үндэсний Комисс
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба
- Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Батлан хамгаалах яам
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
- Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлын командлал
- Тагнуулын ерөнхий газар
- Цагдаагийн ерөнхий газар
- Олон улсын прокуроруудын холбоо (IAP)
- Интерпол
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)
- Төв Азийн болон Евразийн прокурорын байгууллагууд
- Шинжлэх ухааны академи
- Гадаадын болон дотоодын их сургууль, коллеж, судалгааны хүрээлэн, академи
- Кибер аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг компаниуд (ICT, финтек, дата хамгаалалт г.м.)
 - JICA, KOICA, USAID, GIZ зэрэг хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага
 - Монголын хуульчдын холбоо
 - Монголын өмгөөлөгчдийн холбоо

- Монголын криминологичдын холбоо
- Иргэний нийгмийн байгууллага

Хурал зохион байгуулах хэлбэр:
Танхим болон цахимаар

Явагдах газар:
Монголын Улаан Загалмай нийгэмлэгийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв

Хурал зохион байгуулах хугацаа:
2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 10.00-16.00 цаг

Илтгэлийн ерөнхий чиглэл:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх онолын чиг хандлага:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай криминологийн онолын хөгжил, хувьсал;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын философи, эрх зүйн болон нийгмийн ухааны суурь үзэл санаа;
- Кибер криминологийн үзэл санаа;
- Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэлэг хандлага;
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх онолын үндэс.

2. Кибер гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага:

- Олон улсын болон Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага;
- Монгол Улс дахь кибер гэмт хэрэгт үзүүлэх хүчин зүйлийн судалгаа;
- Олон улс, бүс нутгийн статистик, харьцуулсан судалгаа;

3. Эрх зүйн зохицуулалт ба хууль сахиулах үйл ажиллагаа:

- Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал;
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчны харьцуулалт;
- Хууль тогтоомж дахь кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн илрэл;
- Олон улсын гэрээ, конвенц, харьцуулсан эрх зүйн судалгаа;
- Хууль сахиулах байгууллагын кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратеги, чиг хандлага;
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, харьцуулалт.

4. Кибер орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил;

- Кибер орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон улсын туршлага;
- Кибер орчныг ашиглаж хүүхдийг ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, бэлгийн мөлжлэг үйлдэх явдлаас сэргийлэх арга зам;

- Сэтгэл зүй, боловсролын нөлөөлөл;
- Үе тэнгийн бүлгийн харилцааны онцлог ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжууд
- Хүүхдийн гэмт хэрэгт өртөх эрсдэл ба урьдчилан сэргийлэх бодлого.

5.Мэдээллийн технологи ба инновац:

- Хиймэл оюун, өгөгдлийн шинжилгээ ашиглан кибер гэмт хэргийг илрүүлэх;
- Кибер аюулгүй байдлын шинэ шийдэл, программ, платформ;
- Гэмт хэргийн динамик, түвшин, бүтцийн судалгаа;
- Гэмт хэргийн урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, нөлөөллийн үнэлгээ;
- Гэмт хэргийн эрсдэлийн үнэлгээний загвар, аргачлал;
- Урьдчилан сэргийлэх ажлын инноваци: Community policing, restorative justice;
- Дижитал хяналтын систем, мэдээллийн аюулгүй байдлын аргачлал;
- Хиймэл оюун, том өгөгдөл (big data)-ийн хэрэглээ.

6.Олон улсын хамтын ажиллагаа:

- Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа;
- Мэдээлэл солилцох, нотлох баримт цуглуулах олон улсын туршлага;

7.Нийгмийн мэдлэг, боловсрол, урьдчилан сэргийлэх ажил:

- Иргэдийн кибер аюулгүй байдлын боловсрол;
- Кибер орчны зохистой хэрэглээ;
- Олон нийтийн оролцоонд сууринсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ёс суртахууны үнэт зүйл, шашин, соёлын нөлөө;
- Хэвлэл мэдээлэл, кибер орчны нийгэмд үзүүлэх урвуу нөлөө;
- Иргэдийн эрх зүйн боловсрол, эрх зүйн соёл.

Илтгэлд тавигдах шаардлага:

A.Илтгэлийн агуулгад:

- Сэдвийн агуулгын хүрээнд бичсэн байх;
- Судалгааны ажил бодит баримт, судалгааны үр дүнд үндэслэсэн байх;
- Шинэлэг санал, дүгнэлттэй байх.

Б.Илтгэлийн бүтцэд:

- Илтгэл нь сэдвийн нэр, товч агуулга, түлхүүр үг, үндсэн хэсэг, судалгааны хэсэг, дүгнэлт, санал, эх сурвалжаас бүрдсэн байх;
- Үзүүлэх материалуудыг хавсаргаж болно /дүрс бичлэг, гэрэл зураг, схем гэх мэт/.

В.Илтгэлд тавигдах техник шаардлага:

- Microsoft Office Word, Arial, үсгийн хэмжээ 11, хуудасны зүүн талаас 3.0 см, дээд доод талаас 2.0 см, баруун талаас 1.5 см зйтай, А4 формат, мөр хоорондын зай 1.15 байна. Илтгэгч овог, нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим хаягаа

бичнэ. Илтгэлийг хамтран бичиж оролцож болно.

-8-12 тал байна;

-Илтгэлийн сэдвийн нэр, овог нэр, албан тушаал, товч агуулга, түлхүүр үгийг англи хэлээр орчуулсан байна;

-Илтгэлийн эхийг хэвлэмэл эсхүл цахимаар хүлээн авна;

Цагийн зохион байгуулалт:

-Илтгэл хэлэлцүүлэх хугацаа: 15 минут;

-Асуулт хариулт: 5 минут байна.

Эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалт:

Олон Улсын эрдэм шинжилгээний хурал нь нээлтийн, үндсэн, хаалтын хуралдаанаас бүрдэнэ.

Олон улсын хурлаас эмхэтгэлийг эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгох бөгөөд илтгэл хэлэлцүүлсэн эрдэмтэн, судлаачдад батламж олгоно.

Илтгэл хүлээн авах хугацаа: Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнд odgerel.b@uia.gov.mn, ganzagas.b@uia.gov.mn цахим хаягаар 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 17.00 цаг хүртэл хүлээн авна.
Утас: 99093612

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ